

МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2017.01.11, ЛХАГВА ~ №007 (553)

ҮНЭ: 600Т

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Ерөнхийлөгч өнөөдөр сэтгүүлчидтэй зангиагүй уулзалт хийж, утааны талаар ярилцана.
ҮАБЗ утааг гамшиг мөн гэж үзэн, Хотын даргын шийдвэрийг дэмжлээ.
Казиногийн хуулийн төслийг судлах Ажлыг хэсгийг УИХ-ын гишүүн Л.Энхболд ахална.
Дархан-Уулын АН-ын гишүүд бүртгэл шударга явагдаагүй гэж шаардлага хүргүүлээ.
СЕХ-ны гишүүн Д.Дэлгэрцогтыг чөлөөлж, оронд нь ЦЕГ-ын дарга Ө.Энхтөрийг томилно.

ЭДИЙН ЗАСАГ

Монголбанк валютын дуудлага худалдаагаар 6.2 сая ам.доллар банкуудад нийлүүлээ.
Хөрөнгийн биржийн индекс 847.12 нэгж болж, 0.13 хувиар өсөв.
"Хөрөнгө оруулагч үндэстэн" компанийн үнэлгээ 2.7 тэрбум төгрөгтэй тэнцлээ.
Ам.долларын ханш хоёр өдөр дараалан буурав. Харин урвуу хамааралтай алтны ханш өслөө.
Дэлхийн хоёр дахь том эдийн засаг БНХАУ-ын үйлдвэрлэлийн үнийн индекс 5.5 хувиар өсөв.

НИЙГЭМ

Шинэ нисэх онгоцны буудлыг хүлээж авах Ажлын хэсгийн дүгнэлт энэ сарын 18-нд гарна.
Иргэний үнэмлэхний чипийг идэвхжүүлж, тоон гарын үсэг суулгахаар хуульд тусгажээ.
Тээврийн хяналтын прокурор байсан Х.Тамир нарын хар тамхины хэргийг өнөөдөр шүүнэ.
Беларусиас хөдөө аж ахуйн төхөөрөмжийг хөнгөлөлттэй зээлээр авах талаар хэлэлцэв.
Өнгөрсөн жил 17118 хос гэрлэлтээ бүртгүүлсэн бол 4159 иргэн гэрлэлтээ цуцлуулжээ.

ДЭЛХИЙ

Өмнөд Солонгос АНУ, Японтой хамтарсан цэргийн сургуулиаас татгалзав.
Сүүлийн өдрүүдэд Европт хэт хүйтэрсний улмаас 20 гаруй хүн нас барсан байна.
Б.Обамагийн захиргаа Арабын хаврын үр дүнг буруу тооцсоныг ТТГ зөвшөөрлөө.
Филиппиний Жоло арлын орчимд 7.3 магнитудын хүчтэй гүний газар хөдлөлт болов.
Финландын эрдэмтэд хүүхдийн диабет вирусийн гаралтай байж болохыг тогтоожээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2017.01.11

-16° -27°
ҮҮЛШИНЭ

ЦАГ АГААРЫН ДЭГЭРЭЖИГҮЙ МЭДЭЭЛИЙГ 7 ДУГААР НУУГУУС ҮНИШНА УУ.




Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Хоёр хувийн өсөлттэй жил



1.6 хувиар агшаад буй Монголын эдийн засаг энэ онд хоёр хувиар тэлнэ гэж Дэлхийн банк таамаглаж байна. Гэхдээ амаргүй сорилтууд тулгарна гэдгийг сануулав. ►11

Б.Ганбаяр/ЗГМ©



НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН
Өөрийгөө тэтгэх ипотек
Ипотекийн зээл зогсолтгүй үргэлжлэх баталгаа нь санхүүжилт

Б.Баяртогтох
@bayrtogtkzhZGM


“Иргэдийг орон сууцжуулах бодлого үргэлжлэн хэрэгжинэ” хэмээн Монголбанкны ерөнхийлөгч Н.Баяртсайхан мэдэгдээд багагүй хугацаа өнгөрч байна. Түүний энэ үг тухайн үед ипотекийн зээлд хамрагдах хүсэлтэй олон хүний санааг амраасан. Учир нь зах зээлийн хүүнээс хоёр дахин бага хүүтэй орон сууцны зээл зогсох нь гэсэн цуу яриа иргэдийн дунд газар аваад байлаа. Сонгуулиас хойш гурван сарын хугацаанд банкууд ипотекийн зээл олгоогүй. Энэ нь цуу яриа гарах эхлэл болсныг үгүйсгэхгүй. Харин төв банкны ерөнхийлөгчийн дээрх үг энэ эргэлзээг тайлсан юм.

Агаарын бохирдлыг үүсгээд байгаад гол шалтгааны нэг нь гэр хорооллын утаа. Үүнийг шийдэхэд ипотекийн зээлийн ач холбогдол их. Гэвч жилийн найман хувийн хүүтэй ипотекийн зээл санхүүжилтийн хомсдол орох эрсдэлтэй тулгараад байна.

►3

ЗГМ: ИНФОГРАФИК

МОНГОЛ УЛСАД ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ (2016 оны байдлаар)



УЛААНБААТАР

Газар хөдлөлтийн идэвхжил намдахгүй байна

Зөвхөн 2016 онд Эмээлтийн хагаралын дагуу 800 удаа газар хөдөлжээ

З.Цэлмэг
@tselmegZGM

Нийслэл орчмын газар хөдлөлтийн идэвхжил өнгөрсөн онд дахин нэмэгдсэн нь тайвширч болохгүйг бидэнд санууллаа.

2005 оноос хойш нийслэлийн эргэн тойрон 150 км дотор байрлах зургаан хагарал дагуух

газар хөдлөлтийн идэвхжил огцом нэмэгдэж, 2013 онд оргил үедээ хүрсэн билээ. Тус онд нийт 2184 газар хөдлөлт бүртгэгдсэн нь 2006 онтой харьцуулахад долоо дахин өндөр үзүүлэлт болохыг Одон орон, геофизикийн хүрээлэнгээс мэдээлсэн. Тэгвэл 2014, 2015 онд давтамж нь хоёр дахин багасаад байсан идэвхжил өнгөрсөн жил дахин нэмэгдэв. Өөрөөр хэлбэл, 2016 онд бүртгэгдсэн газар хөдлөлтийн идэвхжлийн тоо өмнөх оныхоос даруй 500 орчмоор илүү байна.

2016 онд нийслэл орчимд нийт 1589 газар хөдлөлт бүртгэгдэв.

►5



Ардчилсан намынхан Трампын томилгооны эсрэг

Кортни Вивер, Барни Жопсон, Дэвид Линч

АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргад нэрийг нь санал болгосон Рекс Тиллерсоныг Оростой холбоотой гэж үзэж байгаа бол сайдад нэр дэвшсэн бусад хүмүүс ч асуудалтай тулгарах бололтой. Тэрбээр Оросын Давос болох Петербургийн эдийн засгийн чуулганы индрийн төвд сууж байв. Түүний баруун гарт Москвагийн хамгийн хүчирхэг хоёр хүн Ерөнхийлөгч Владимир Путин, нефтийн магнат Игорь Сечин нар байрлажээ. 2013 оны

зургадугаар сарын энэ өдөр Exxon компанийн захирал ноён Тиллерсоны хувьд маш чухал байлаа.

Түүний компани Роснефть компанитай хамтран Хойд мөсөн далайд хайгуулаа өргөжүүлэхээр шийдвэрлэж, ноён Путин түүнийг Найрамдлыг одонгоор шагнажээ. Гэвч энэ өдрийн үйл явдал Трампын Төрийн нарийн бичгийн даргаар сонгогдсон Тиллерсоны сенатаар батлахад тээг болж магадгүй юм.

►9

MSE ALL	АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	5-ЧИНГИС БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
847.12 0.13%	1186.20 0.46%	5591 0.02%	85.789 0.01%	96.570 0.03%	2489.75	360.77	41.70

Улс төр

НАМУУД

АН-ын таван араншин ба амлалт

Мөрийн хөтөлбөрөө танилцуулах ажлынхаа талд нь ороод байна

Б.Даваатогтох
@datoZGM

Эв нэгдлийг эрхэмлэсэн Ардчилсан намын даргын сунгаанд өрсөлдөж буй таван нэр дэвшигч эхний уулзалтаасаа л эвдрэлцэж эхэлсэн. Өмнө нь зохион байгуулсан хоёр удаагийн дотоод сонгуулийн дараа Ардчилсан нам золтой л тарчихаагүй учир энэ удаад эв нэгдлийг эрхэмлэх ёстойг ийнхүү намын дарга нь хатуу захиж, эв эеийг хичээхийн бэлгэдэл болсон багцалсан таван сум өгсөн юм. Гэвч нэр дэвшигчид мөрийн хөтөлбөрөө танилцуулах нэрийдлээр нэгнээ намнаж, дотоод сонгуулийн “цаг уур”-ыг зориудаар өөрчлөв. Товчхондоо, мөрийн хөтөлбөрөө танилцуулж, намынхаа гишүүдээ оноо цуглуулах ёстой дотоод сунгааны өнгө төрх, үндсэн зорилго нь алдагдахад хүрээд байна.

Өнөөдрийн байдлаар сунгаанд өрсөлдөж буй таван нэр дэвшигч дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрөө танилцуулах ажлынхаа талд нь ороод буй. Тодруулбал, Хэнтийгээс эхэлсэн сонгуулийн сурталчилгаа Дорнод, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр, Сүхбаатар, Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан аймагт үргэлжлээд нэр дэвшигчид өчигдөр Улаанбаатар хотноо ирлээ. Үүнээс гадна нийслэлийн есөн дүүргээс зөвхөн Багануур, Багахангай дүүрэгт л таван нэр дэвшигч буугаад мордсон. Ингэхдээ нэр дэвшигч УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат Ардчилсан намын шинэчлэл гэхээсээ



Б.Ганбаяр / ЗГМФ

илүүтэйгээр гишүүд, дэмжигчдээ идэвхжүүлэх, алдаа дутагдлаа дүгнэх хэрэгтэйг онцолж байна. Мөрийн хөтөлбөртөө ч ардчилсан төрийн удирдлага зөвхөн эрх баригчдаар биш иргэдийн шууд оролцоотой удирдлага дээр тогтох ёстойг тусгажээ. Үүнээс гадна улс төрийн хариуцлага тооцохгүй өнгөрдөг хөшүүн тогтолцоог өөрчилж, улс төрийн чадавхын үнэлгээ нэвтрүүлэхээр тэрбээр зорьж байгаа аж.

Алдаа дутагдлаа дүгнэх ёстой гэсэн байр суурийг илэрхийлж байгаа нэр дэвшигч үүгээр дуусахгүй. Ерөнхий сайд асан Н.Алтанхуяг намын даргаар сонгогдсон даруйдаа өнгөрсөн дөрвөн жилийн намын үйл ажиллагаа, бодлого шийдвэрт дүгнэлт хийнэ гэдгээ уулзалтын үеэр амлажээ. Тэрбээр орон нутгийн намыг бэхжүүлж, хүчирхэгжүүлэн, намын бодлогыг орон нутагт чиглүүлж, гишүүдийнхээ шууд

оролцоог хангана гэдгээ мөрийн хөтөлбөртөө дурдсан байна.

Харин УИХ-ын гишүүн Ж.Батзандан нам дамнасан бүлэглэл, фракцаас Ардчилсан намыг салгах нь шинэчлэлийн суурь ажил хэмээн тодорхойлжээ. Үүнээс гадна өөрт нь үе үе тулгардаг ужиг “өвчин”-өөс салахыг хүссэн бололтой. Мөрийн хөтөлбөртөө намын гишүүдээ хөөдөг, ялгаварладаг хоцрогдсон тогтолцоог халж, дүрмийн зөрчил гаргасан гишүүдийг улс төрийн сонгуульд оролцох, сонгуульд албан тушаал хаших эрхийг нь тодорхой хугацаагаар түдгэлзүүлдэг хариуцлагын тогтолцоог нэвтрүүлэхийг чухалчилсан байна.

УИХ дахь Ардчилсан намын бүлгийн дарга С.Эрдэнийн хувьд намаа санхүүжилтийн хувьд хэн нэгэн болон хэсэг бүлгээс хараат бус байлгахыг мөрийн хөтөлбөртөө онцолжээ. Товчхондоо, санхүүгийн хувьд бие даасан байх ёстой хэмээн

» Мөрийн хөтөлбөрөө танилцуулж, намынхаа гишүүдээс оноо цуглуулах ёстой дотоод сунгааны өнгө төрх, үндсэн зорилго нь алдагдахад хүрээд байна.

» Н.Алтанхуяг намын даргаар сонгогдсон даруйдаа өнгөрсөн дөрвөн жилийн намын үйл ажиллагаа, бодлого шийдвэрт дүгнэлт хийнэ гэдгээ уулзалтын үеэр амлажээ.

» Орон нутаг төвтэй нам болохын төлөө ажиллана.

үзэж байгаа аж. Мөн орон нутаг төвтэй нам болохын төлөө ажиллана гэдэг заалтыг мөрийн хөтөлбөртөө тусгажээ.

Нэр дэвшигч Л.Гантөмөрийн хувьд мөрийн хөтөлбөртөө мэдлэг боловсролыг чухалчилсан байна. Тодруулбал, намын хүний нөөцийн бодлогод мерит буюу мэдлэг, ур чадвар, туршлагыг эрхэмлэж, оролцоо манлайллыг чухалчилдаг зарчим баримтална гэх заалтыг тусгажээ. Мөн намын дэргэд улс төрийн боловсролын сургалтын бүтэц үүсгэнэ гэдгээ ч онцолсон байна.

Ямартай ч, сонгогчдын хувьд намын эв нэгдлийг бататгаж, шинэчлэл хийхийг хамгийн ихээр хүлээж буй. Нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрт ижил төстэй заалтууд ч харгадсан. Гэхдээ хэн нь олон санал авч ялалт байгуулна бусад нэр дэвшигчийнхээ мөрийн хөтөлбөрийг багцалж, хамтран хэрэгжүүлэхээ албан ёсоор амласан юм. [ЗГМ]

ТОВЧХОН

» ЦЭЦ

Сонгуулийн тухай хуулийн санал тоолох, саналын хуудас, санал хураалтыг хүчингүйд тооцохтой холбоотой зарим зүйл иргэний сонгох болон сонгогдох, шүүхэд хандах эрхийг хязгаарлаж, Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэсэн гомдлыг нэр бүхий иргэд Үндсэн хуулийн цэцэд ирүүлжээ. Үндсэн хуулийн цэц уг маргааныг энэ сарын 18-нд хянан хэлэлцэнэ.

» АЖЛЫН ХЭСЭГ

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос Казино байгуулах тухай хуулийн төслийг судлах Ажлын хэсэг байгууллаа. Ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Л.Энхболд ахлах аж. Өмнөх парламентын үед Засгийн газраас Казино байгуулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн бөгөөд хэлэлцэхийг дэмжиж байжээ.

» УУЛЗАЛТ

Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил АНУ-ын Мянган сорилтын корпорацийн Европ, Ази, Номхон далай, Латин Америкийн орнуудыг хариуцсан захирал Жонатан Брүүкс тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзлаа. Тус корпорацийн Удирдах зөвлөл өнгөрсөн оны арванхоёрдугаар сард Монголыг хоёр дахь компакт гэрээ байгуулах боломжтой орноор дахин шалгаруулсан юм. Энэ хүрээнд тус байгууллагын төлөөлөгчид Монгол Улсад ажиллаж байна.

» ТОО

180.7

Мянган тонн. Одоогоор манай улс ураны 12 ордын хэмжээнд 180.7 мянган тонн геологийн нөөц бүртгэсэн байдаг аж. Үүнээс есөн ордын нөөцийг нь Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар баталгаажуулсан байна. Харин улсын хэмжээнд цацраг идэвхт 12 ордын талбайд долоон компани үйл ажиллагаа явуулдаг аж.

» ТӨСӨЛ

УИХ-ын гишүүн Б.Жавхлангийн өргөн мэдүүлсэн Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл парламентын босго давлаа. Хөгжлийн банкыг улс төрөөс хараат бус, бие даан ажиллах боломжийг хангахаар уг төслийг боловсруулжээ.

» ХАМТЫН АЖИЛЛАГАА

БСШУС-ын сайд Ж.Батсуурь Бугд Найрамдах Куба Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Раул Дэлгадо Консалсионыг хүлээн авч уулзлаа. Энэ үеэр Элчин сайд тус улсад зохион байгуулагддаг кино фестивальд Монгол Улсын уран бүтээлчдийг оролцуулах боломжтойг дурдлаа. Мөн 1994 оноос хойш нийт 140 гаруй оюутанд Кубын Засгийн газраас тэтгэлэг олгосон бөгөөд цаашд ч энэ тоог нэмэгдүүлэх боломжтойг онцолсон юм.

» ШААРДЛАГА

Ардчилсан намын гишүүдийн шинэчилсэн бүртгэл өндөрлөсөн. Тэгвэл Дархан-Уул аймгийн Ардчилсан намын хорооноос шинэчилсэн бүртгэлийг дүрмийн дагуу хийгээгүй хэмээн үзэж, шаардлага хүргүүлжээ. Хэрэв шаардлагыг хүлээж аваагүй тохиолдолд тэмцлийн дараагийн хэлбэрт шилжихээ мэдэгджээ.

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжлагатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» OPED@ZASAG.CO

Утас: 99901526 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

ЗГМ: ТОДРУУЛГА

С.Чинзориг: Татвар төлөгч иргэн жилд 240 мянган төгрөгийн хөнгөлөлт эдэлнэ

Б.Тогтох
ЗГМ

УИХ-ын нэр бүхий гишүүд Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн. Энэ талаар төсөл санаачлагч, УИХ-ын гишүүн С.Чинзоригоос дараах зүйлийг тодрууллаа.

«Хуулийн төслийн гол агуулга нь юу вэ. Төслийг баталснаар иргэдэд ямар ач холбогдолтой вэ?»

«Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт саарч, аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн чадавх суларснаас цалин хөлс төдийлэн нэмэгдсэнгүй. Цаашид дорвитой нэмэгдэх хандлага ажиглагдахгүй байна. Энэ байдал нь иргэдийн, ялангуяа бага орлоготой хэсгийн амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлж байгаа. Иймд хувь хүний орлогын албан татварт үзүүлэх хөнгөлөлтийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулах замаар бодит орлого, худалдан авах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор дээрх хуулийн төслийг боловсруулсан.

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг сард 240 мянган төгрөгөөр тогтоож, энэ сарын 1-нээс мөрдөж эхэллээ. Хувь хүний орлогын албан татварт үзүүлэх хөнгөлөлтийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод



Б.Ганбаяр / ЗГМФ

хэмжээтэй тэнцүү байхаар хуульчлан тогтоовол татвар төлөгч иргэн жилд 240 мянга, сард 20 мянган төгрөгийн хөнгөлөлт эдлэх боломж бүрдэнэ.

«Хуулийн үйлчлэлд зөвхөн төрийн албан хаагчид хамрагдах уу?»

«Үгүй ээ. Бидний тооцоолсноор Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн хөнгөлөлтөд орлого багатай 600 орчим мянган хүн хамрагдахаар байгаа. Өөрөөр хэлбэл, зөвхөн төрийн албан хаагчдын цалин нэмснээс илүү өргөн цар хүрээг хамарна. Нөгөөтэйгүүр, энэхүү

Өмнө нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлдөг хууль хэрэгжиж байсан.

иргэдийн бодит орлого нэг татвар төлөгчид сард 13 мянга, жилд 156 мянган төгрөгөөр өснө. Нийгмийн даатгалын санд цалин хөлсөө мэдүүлж шимтгэл төлөгч 575 мянган иргэн байгаа бөгөөд татварын хөнгөлөлт эдэлсэн иргэдийн бодит орлого 89 тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ гэсэн тооцоог гаргасан.

«Жижиг, дунд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн. Хуулийн төсөл боловсруулах болсон шалтгаан нь юу вэ?»

«Жижиг, дунд үйлдвэрлэл ажлын байр нэмэгдүүлж, бий болгодог. Иргэдийг байнгын, тогтмол орлоготой болгодог үндсэн арга хэлбэр шүү дээ. Тийм ч учраас УИХ, Засгийн газраас жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор зайлшгүй дэмжих шаардлагатай байдаг. Нэг үеэ бодвол жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарт улсын төсвөөс эх үүсвэрийг нь шийдэж өгөөд зээлийн санг нь бүрдүүлээд явж байна. Энэ онд гэхэд л төсөвт 40 тэрбум төгрөгийг жижиг зээл маягаар үйлдвэрлэл эрхлэгчдэд зорилготой гэж ойлгож болно.

«Хуулийн төсөл баталвал төсөвт хэчнээн төгрөгийн дарамт үүсэх вэ?»

«Хуулийн төслийн хэрэгжих хугацааг 2018 оны нэгдүгээр сарын 1-нээс мөрдөхөөр тусгасан. 2018 онд улсын төсөвт төрийн албан хаагчдын цалин татвараас төвлөрөх орлого 89 тэрбум төгрөгөөр буурах боловч

Нийтлэлчийн булан

Өөрийгөө тэтгэх ипотек

Зээл хүссэн гурван иргэн тутмын нэг нь зээлдэгч болж байна

Энэ нь хамгийн их эрэлт, хэрэгцээтэй, нийгмийн захиалга болсон зээлийн бүтээгдэхүүн цаашид тогтвортой орших, эсэхийг тодорхойлох юм. Тиймээс санхүүжилт нь ипотекийн хөтөлбөр зогсолтгүй үргэлжлэх баталгаа. Уг нь ипотекийн зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх замаар илүү олон өрх орон сууцтай болох нөхцөлийг бүрдүүлэх нь чухал. Үүнийг цөөнгүй эдийн засагч учирладаг. Тэдний зарим нь орон сууцны урьдчилгааг зохих хэмжээнд бууруулах, эсвэл зээлийн хүүг одоогийн түвшнээс багасгах нь утаагүй зуух, шахмал түлшнээс хамаагүй дээр сонголт гэж үздэг.

Тэгвэл үүнтэй санал нэгдэхгүй нь иргэдийн цалинг өсгөх байдлаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой. Энэ нь ипотекийн зээлд олон иргэн хамрагдахад хэрэгтэй гэж дүгнэдэг хэсэг. Өрхийн дундаж орлого нэмэгдэхийн тулд эдийн засгийн тамир тэнхээ сайн байх нь зүйн ёсных. Эдийн засаг тогтвортой өсөх нь өрхийн орлогод бодитой нөлөөлдөг.

Нийслэлийн айл өрхийн 58.1 хувь нь гэр хороололд амьдарч байгаа гэсэн статистик бий. Манай улсын хувьд эдийн засгийн хүндрэл он дамнан үргэлжилж буй. Ийм нөхцөлд төгрөг хэвлэх замаар



Б.Ганбаяр / ЗГМӨ

ипотекийн зээлийг санхүүжүүлэх боломжгүй гэдгээ төв банкны зүгээс зарласан. Энэ нь Монголбанк найман хувийн хүүтэй зээлийн санхүүжилтээс нэг мөр гарч байгаа гэсэн үг биш юм.

Ипотекийн хөтөлбөрт төв банк нийт дөрөв орчим их наяд төгрөг зарцуулаад байна. Үүний эргэн төлөлт, хүүгийн төлбөр нийлээд сард болгон ойролцоогоор 30 гаруй тэрбум төгрөг бүрдэж байгааг дуулгая. Монголбанк энэ мөнгөөр ипотекийн зээлийг санхүүжүүлж байна. Орон сууцны ипотекийн санхүүгийн тогтвортой тогтолцоог бий болгохоор дөрвөн жилийн өмнө дээрх хөтөлбөрийг Засгийн газар Монголбанкт хамтран эхлүүлсэн. Харин Засгийн газар

өнөөдөр найман хувийн зээлийн санхүүжилтийн мухардалд орсон тул төв банк руу шилжүүлсэн нь нууц биш ээ.

Төв банк сүүлийн хоёр сарын төгрөг орон сууцны зээлийн санхүүжилтэд зарцуулжээ. Ипотекийн зээлийн эргэн төлөлтөөр дараагийн зээлээ санхүүжүүлж байгаа нь энэ. Монголбанкаас өмнө нь шинэ эх үүсвэр гаргах замаар ипотекийн зээлийг санхүүжүүлсэн. Харин өнгөрсөн оноос дээрх зарчмаар ипотекийн зээлийг олгож байна. Санхүүжилт буурсантай холбоотойгоор арилжааны банкуудын зээлийн шалгуур босго өндөрсөж, урьдынх шиг таван зээл тутмын дөрөв гардаг үе

ард хоцорсон билээ. Ипотекийн хөтөлбөр ид хэрэгжиж, эрэлт их байх үед сар тутам 60 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилт зээл болон гарч байсан. Харин эрэлт хумигдсан энэ үед 30-35 тэрбум төгрөг боломжийн хувилбар гэж төв банк үзэж байна. Гэхдээ энэ нь утааны эсрэг дорвитой өөрчлөлт авчрах хэмжээний мөнгөн дүн биш юм. Учир нь сар тутам дээрх мөнгөн дүнгээр 1000 хүрэхгүй өрх орон сууцны зээл хамрагдаж байна. Тэгэхээр зээл хүссэн гурван иргэн тутмын нэг нь зээлдэгч болох нь.

Банкуудын ипотекийн зээлийн тайланг сар болгон төв банк танилцуулдаг. Ипотекийн зээлд хамрагдсан иргэдийн тоо

90 мянга руу ойртлоо. Хугацаа болон чанаргүй зээлийн үзүүлэлт ипотект маш бага хувийг эзэлдэг. Хэдийгээр ипотекийн зээлийг хэвийн олгож байгаа ч удаахрах болсон.

Төгрөгийн эсрэг ам.долларын ханш чангарсан хэвээр буй. Монголбанкны зарласан ханшаар мягмар гарагт 2498.48 төгрөгтэй тэнцлээ. Төв банк энэ өдөр 2498 төгрөгийн ханшаар банкуудад 6.2 сая ам.доллар нийлүүлэв. Ханшийн огцом хэлбэлзлийг чөдөрлөх аргуудын нэг нь энэ. Ипотекийн зээлийн үлдэгдлийн 99.8 хувь нь төгрөгийнх. Үлдсэн хувийг валютын зээл бүрдүүлж байна. Сар тутам олгож буй ипотекийн зээл өмнөх сараас буурсан дүнтэй байгаа юм. Энэ нь санхүүжилт хомсдож буйн илрэл. Нөгөө талаасаа эдийн засаг агшиж байгаагай холбоотойгоор зээлийн эрэлт хумигджээ.

Ашиглахад бэлэн болоод буй 20 гаруй мянган орон сууц бий. Иргэдийн орон сууцны худалдан авалт буурч байгаа нь барилгын компаниудад сөрөг нөлөө үзүүлэх болов. Шинээр ашиглалтад орох болон захиалга авч буй орон сууцны тоо буурч байна. Энэ нь орон сууц худалдан авах эрэлтээс харьцангуй өндөр хэвээр байгааг “Инфляцийн төлөв байдлын тайлан”-д тэмдэглэжээ. Орон сууцны үнэ цаашид буурах чиглэлтэйг “Тэнхлэг зууч” компаниас мэдээлсэн юм. Иргэдийн орон сууц худалдан авах чадвар буурахтай зэрэгцэн орон сууцны үнийн хөөс намжиж буй. Энэ нь байр авахаар төлөвлөж байгаа өрхөд таатай боломж. Гол нь энэхүү боломжийг илүү олон өрх ашиглах нь чухал юм. [ЗГМ]

Шилдгүүдийг нэг дороос...

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИНЫ
2017 ОНЫ I УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА.
ЗАХИАЛГЫН ҮНЭ: 21,000₮

УЛИРАЛД

44 ДУГААР



Блю Скай тауэр, 4 Давхар, № 407, Энхтайваны өргөн чөлөө 17, 1-р хороо
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс, И-мэйл: info@zasag.co
Утас: +976 70103131, Факс: +976 70106065, Вэб: ubinfo.mn

Загвар

Гарын зүүлт, алтлаг шанх, хатгамалтай цамц трэнд боллоо

Г.Сайнзаяа
@sainzayaZGM

Нэг үеэ бодвол монголчууд Цагаан сарын хувцаслалтад ихээхэн анхаарч, ноёд, хатад шиг л гоёх болж. Ингэхдээ гэр бүлээрээ ижилсэж, нэг хэв загварын дээд, цамц өмсөхийг илүүд үзэж байгаа юм. Цагаан сар гэхээр зарим хүнд хол сонсогдож байж мэдэх ч Монголын хувцас загварыг эрхэмлэгч “нийгэмлэгийнхэн” одооноос догдолж эхэлжээ. Баяраар өмсөх гоёлоо оёулах нэг нь төсөөлж, авах нэг нь хайж, зарим нь бартердахаар төлөвлөж буйтай олон таарлаа. Тиймээс загвар сонирхогчдод Гал тахиа жилийн үндэсний хувцасны трэнд хаашаа эргэснийг толилуулж байна.

ГОЁЛ

Энэ жилийн трэнд гоёл бол сугаж буюу эрдэнийн шигтгээ, чулууг нарийн сүлжсэн утсаар тойруулж оёсон чимэг юм. Сугаж гоёлыг анхлан оруулж ирсэн



Хувийн архиваас ©

сүүлийн үед нимгэн, хөнгөн юм өмсөх хүсэлтэй болжээ. Хуучных шиг хурган дээл өмсчихөөд л хөлрөөд суух хүсэл алга гэх юм. Цэвэрхэн өнгө, хийцтэй хэрнээ эрхэмсэг зүйл сонирхдог болж. Өнгийн оруулга гэхээс биш хэтэрхий эрхэн алаг хээтэй хувцас моодноос гарчихлаа. Түүнчлэн энгийн монгол зах, монгол энгэртэй цамц, дээл хүмүүс их захиалж байна” хэмээлээ.

Цагаан сараар ХӨНГӨН, НИМГЭН, ХЯМД ХУВЦАСЛАХЫГ ЗОРЬЖ БАЙНА

Тус захиалгын газарт эмэгтэй энгийн дээл 100-120, загварлаг бол 120-180 мянган төгрөгөөр оёдог аж. Гэхдээ энэ бол материал ороогүй үнэ гэдгийг санаарай. Дашрамд дуулгахад, Нарантуул худалдааны төвд торго, үйтэн хуар 25-40 мянган төгрөгийн хооронд хэлбэлзэж байлаа. Харин эрэгтэй энгийн дээл 120-150, загварлаг нь 140-200 мянган төгрөгийн үнэтэй. Эцэст нь хэлэхэд, та моод дагадаг хүн биш гэхнээ цагаан сараар үндэсний хувцсаараа гоёхыг хүсдэг бол дээлнээс өөр олон сонголт бий болсныг дуулгахад таатай байна.

Үндэсний хувцасны хэрэглээ

Хувцас захиалгын газруудын хийсэн хурган дээл хамгийн багадаа 350 мянган төгрөгийн үнэтэй байна.

Минимализм эрчээ авсан Цагаан сар

томоохон төлөөлөгч бол Сийлэн Гоо брэнд. Харин сүүлийн үед бүсгүйчүүд гараар урлаж зарах болжээ. Сугаж гоёлын дундаж үнийг танилцуулбал, зүүлт 60, ээмэг 30, бөгж 25 мянган төгрөг. Түүнчлэн алт, мөнгө шиг харагддаг энгийн материалтай ээмэг, шанх, гарын зүүлт эрэлтэй байх төлөвтэйг “MsGuaaMaral” брэндийн дизайнер Г.Марал хэллээ.

ХУВЦАС

Хэдхэн жилийн өмнө хүмүүс хурган дээл, хантааз, монгол гутал гэхчлэн иж бүрэн хувцасладаг байв. Харин сүүлийн үед илүү минималист маягийг эрхэмлэж,




"Siilen Goo" брэндийн сугаж хийцийн гоёл.

тутам болон тэмдэглэлт баяраар гээд хэдийд ч өмсөх боломжтой загварлаг, биед эвтэйхэн, үндэсний хэв шинжийг шингээсэн хувцас гаргахыг зорьдог. Энэ жил монгол захтай, энгэртэй хатгамалтай, ханцуйтай, ханцуйгүй цамцнууд илүү эрэлтэй байна. Материалын

тухайд таар, даавуунаас илүү гоёмсог пүүсүү болон чичүүг сонирхох болжээ. Мөн хатгамал оруулж өгснөөр илүү тансаг харагдуулж байгаа юм” гэв.

“Жаран” төвийн “Чамин” хувцас захиалгын газрын дизайнер, оёдолчин Н.Цэндсүрэн “Хүмүүс

хувьсаж, ууж, хантааз хоцрогдчихоод буйг салбарынхан өөрсдөө ч хэлдэг. Гэхдээ та улнаасаа зулай хүртлээ нүнжитэй сайхан гоёхыг хүсэж байж мэдэх юм. Үнийн хувьд хантаазыг дунджаар 140-200, уужийг 140-160 мянган төгрөгөөр оёж байгаа аж. [3ГМ]



TRANSWEST
MONGOLIA LLC

Your Authorized Komatsu Distributor

EMPLOYMENT OPPORTUNITY

Weld/Machine Shop Supervisor

Ulaanbaatar, Mongolia
Reference Number: WMS0117

Transwest Mongolia is a leading mining equipment distributor that supplies customized solutions to meet the unique requirements of its customers. Transwest Mongolia is a wholly owned subsidiary of SMS Equipment Inc., the largest Komatsu dealer in North America and one of the largest in the world.

We are currently seeking a candidate for the position of **Weld/Machine Shop Supervisor** based in UB at the UB Service Department.

The Role:

Reporting to the Head of Service Department, this position supervises the Welding and Machine Shop Team responsible for completing the daily service and repair activities in support of the Products marketed by Transwest Mongolia, in a safe and productive manner. The Weld/Machine Shop Supervisor will administer processes and procedures ensuring compliance to all company and customer standards. The key responsibilities include:

- Ensures weld/machine shop team has a clear understanding of their job responsibilities by effective supervision, leadership and conducting regular team position description, performance reviews and providing appropriate feedback.
- Supervises the daily activities of the weld/machine shop team ensuring all repairs are completed to the applicable OSHA and other regulatory standards parameters.
- Establishes a work environment that promotes and encourages employee success.
- Ensures all company policy, systems, and industry related training is delivered to all direct reports as needed.
- Ensure documentation is accurately processed, distributed with internal and external departments as required in a timely manner.
- Review all necessary data entry and confirmation is accurate for short and long term recording.
- Works with the planning team to ensure all planned work and scheduled labour plans are executed.

Qualifications:

- Knowledge of Heavy Equipment and Components (5+ Years' experience as Senior Welder)
- Supervisory skills
- Knowledge of Microsoft Office Suite Ability to learn new systems and processes.
- Knowledge of Machining principles, experience operating lathes, milling machines, Horizontal Floor Bores and general machining
- Strong ability to communicate in English, written and verbal

All interested applicants should submit their resume and cover letter referencing the applicable position number in English by **5:00PM, January 15, 2017 to: careers@transwest.mn**

Transwest Mongolia thanks all applicants for their interest, but only short listed candidates for an interview will be contacted.

Transwest Mongolia provides a non-smoking environment



Гоёл чимэглэлийн "MsGuaaMaral" брэндийн гарын зүүлт.

европ болон үндэсний хэв загварыг хослуулж өмсөх болсон. Хувцас захиалгын газруудын хийсэн хурган дээл хамгийн багадаа 350 мянган төгрөгийн үнэтэй байгаа. Нарантуул худалдааны төвд ээтэн гутал 80-120, монгол гутал 150-300, мөнгөн тоногтой ширэн бүс 30-120 мянган төгрөгөөр худалдаж байна. Харин дөрвөн тал нь буудаг малгай 125-350 мянга гэж бодвол Цагаан сараар иж бүрэн хувцаслахад хамгийн багадаа 650 орчим мянган төгрөг болно.

Гэхдээ одоо дэлгэрч буй шинэ хандлага бол хэмнэлттэй, ухаалаг худалдан авалтыг илүүд үздэг. Товчхондоо шинэ жилээр нэг удаа өмсөх даашиг, цагаан сараар нэг өмсөх дээлэнд хэдэн зуун мянган төгрөг үрэх хэрэггүй гэсэн үг юм. Түүний оронд төрөл бүрийн өмд, банзалтай хослуулах боломжтой, өдөр тутамдаа ч өмсөхүйц, үндэсний хэв загвартай цамц 55-110 мянган төгрөгт авч болно. Хувцас захиалгын газарт энгийн монгол цамц 40, загварлаг, нарийн хийцтэй бол 60-80 мянган төгрөгийн үнэ ханшаар хийдэг.

“Go-Go Clothing” үндэсний хувцасны брэндийг үүсгэн байгуулагч, ерөнхий дизайнер Б.Урангоо “Үндэсний хувцсыг өдөр тутамдаа өмсөхөд хэт



"Go-Go Clothing" брэндийн цамц, банзал.

нүсэр байдгаас болж зөвхөн баяр ёслолоор өмсдөг байлаа. Харин одоо үед залуучууд үндэсний хувцас өмсөх хүсэлтэй болсон нь ажиглагдсан. Бидний хувьд өдөр

ЗАСГИЙН ГАЗРЫН МӨДӨӨ
СОНИН АМХ

"Засгийн газрын мэдээ" сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэсний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Тэргүүн орлогч эрхлэгч
Цэвээндолгорын ЦЭВЭЭНХЭРЛЭН
Утас: 99901526

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦИ

Улс төр, нийгмийн мэдээллийн алба
Эдитор Б.Гандолгор
Утас: 99901483

Эдийн засаг, бизнес мэдээллийн алба
Эдитор Б.Баяртотх
Утас: 99901532

Гадаад контент, соёл энтертайментын алба
Эдитор Р.Оюунцэцэг
Утас: 99901621

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Г.Лхагвасүрэн
Утас: 99903581

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайвны өргөн чөлөө,
"Бло Скай таур" 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар: 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР

Zasag.Co
"Чөлөөт хэвлэл"
сангийн хэвлэх үйлдвэрт хэвлэв

Дугаарын удирдагч
Г.Баярсайхан



8465800040291124 00553

Байршил



Mongolian Property Management Group

Real Estate Service · Real Estate Appraiser · Real Estate Developer

Address: Sukhbaatar district, Naryn zam 56, Zamiin tsagdaa,
Tsoma Office, 601, Ulaanbaatar, Mongolia
Phone: +976 8806 8207, +976 8800 3620
www.mpmgroup.mn



BELLA VISTA
Хэмжээ: 165 м2
Өрөө: 3
Граж: 1 машины гражтай
Үнэ: 4,000,000 ₮ /түрээслүүлнэ/
Хаяг: ХУД, Зайсан



GALAXY TOWER
Хэмжээ: 737 м2
Өрөө:
Граж: 40 машины зогсоол
Үнэ: 2550\$/худалдана/
Хаяг: ХУД



RIVER GARDEN
Хэмжээ: 179,8 м2
Өрөө: /4 унтлагын өрөө/
Граж: 2 машины зогсоол
Үнэ: 3,900,000 ₮ /худалдана/
Хаяг: ХУД, Маршалын гүүр



JAPAN TOWN, C4 APARTMENT
Хэмжээ: 138.52 мкв талбайтай
Граж: 1 машины зогсоолтой
Өрөө: 3 өрөө байр түрээслэнэ
Үнэ: 2400\$
Хаяг: ХУД



ОДДЫН ХОТХОН
Хэмжээ: 119 м2
Өрөө: 4
Граж: 2 /20 м2/
Үнэ: 2,500,000 м2 ₮ /түрээс/
Хаяг: ХУД



ЗАЙСАНГИЙН ОРГИЛ
Хэмжээ: 136,06 м2
Өрөө: 5 өрөө байрыг гадаадын иргэнд яаралтай түрээслүүлнэ.
Үнэ: 2000\$
Хаяг: ХУД



SEOUL ROYAL COUNTY
Хэмжээ: 200 м2
Өрөө: 4 /3 давхарт/
Граж: 2
Хаяг: ХУД, Зайсан



EASTERN PLAZA
Хэмжээ: 150-300 м2
Зориулалт: Оффис үйлчилгээ
Граж: Машины зогсоолтой
Үнэ: Зах зээлийн үнээр түрээслүүлэх болон худалдана
Хаяг: Хотын А зэрэглэлийн бүс болох СБД, Сөүлийн гудамж, NARAN Mall их дэлгүүрийн чанх хойно.
Утас: 98995225, 90112555



BUDDHA VISTA
Хэмжээ: 122
Өрөө: 4
Граж:
Үнэ: 750 сая ₮ /худалдана/
Хаяг: ХУД, Зайсан



НҮХТ
Хэмжээ: 900 м2 /газар/
Хэмжээ: 250 м2 /зуслангийн байшин/
Граж: 3 машины зогсоол
Үнэ: 500,000,000 ₮



BRAUNHAUS
Хэмжээ: 100 м2
Өрөө: /2 унтлагын өрөө/
Граж:
Үнэ: 200,000 \$ /худалдана/
Хаяг: Сөүлийн гудамж



ROMANA RESIDENCE
Хэмжээ: Цоо шинэ 66мкв талбайтай
Өрөө: 2 өрөө байр түрээслүүлнэ
Үнэ: 1000\$
Хаяг: ХУД



ҮЛ ХӨДЛӨХИЙН МЭДЭЭЛЛИЙГ ИЛҮҮ ХҮРТЭЭМЖТЭЙ ИЛҮҮ ХЯМДААР

[ЗГМ]

Та үл хөдлөх хөрөнгийн мэдээллээ байршуулахыг хүсвэл доорх утсаар холбогдоно уу.

Утас: 99903584, 99903581



СЭЛБЭ ХОТХОН
Хэмжээ: 172 м2
Өрөө: 4 /пентхаус/
Граж: 2 машины зогсоол
Үнэ: 3,0 ₮ /түрээслүүлнэ/
Хаяг: "Орчлон 1" сургууль



REGENCY RESIDENCE
Хэмжээ: 165 м2
Өрөө: /3 унтлагын өрөө/
Граж: машины зогсоолтой
Үнэ: 335,000 \$ /худалдана/
Хаяг: БЗД, 13 дугаар хороо



BLUE SKY
Хэмжээ: 118 м2
Өрөө: 3
Граж:
Үнэ: 1,500,000 ₮ /түрээслүүлнэ/
Хаяг: ХУД, Зайсан



RE/MAX Mongolia

Танд зориулсан үл хөдлөх хөрөнгийг эндээс...

Хаяг: Баянзүрх дүүрэг, 26 хороо Их хүрээ гудамж,
Парк сайд төвийн 3 давхарт
Утас: 77073399, 94093390, 94043390
http://www.remax.mn



SEOUL PLAZA
А зэрэглэлд байршилтай, нийт 11 давхар, 8800 м2 талбайтай, 1-4 давхарт: Өндөр зэрэглэлийн худалдаа, үйлчилгээний төв 5-9 давхарт: Оффис 10-11 давхарт: Ресторан, лоунж 2016 оны зургадугаар сард бүрэн ашиглалтанд орно.
Хаяг: БГД, "Сөүл плаза" бизнес төв



MD CENTER
Хэмжээ: 2380 м2
Өрөө: 3 давхар, 2 жигүүр
Граж: 30-40 машины ил зогсоол 20 машины дулаан граж
Үнэ: 2,500,000 ₮ /худалдана/
Хаяг: ХУД, 15-р хороо



ЦЭЛМЭГ ТӨВ
Хэмжээ: 9 давхар оффис
Өрөө: тус бүр 624 м2
Граж: ил зогсоол
Үнэ: 60,000-70,000 ₮ /түрээслэнэ/
2200-2900 \$ /худалдана/
Хаяг: СБД, 1-р хороо




9 ЭРДЭНЭ
Хэмжээ: 642 айлын орон сууц
Өрөө: 2-3
Граж:
Үнэ:
Хаяг: БГД 3-р хороо



ПАРКСАЙД РЕЗИДЕНС
Хэмжээ: 52.58-178.47 м2
Өрөө: 2-5
Граж:
Үнэ: 2,600,000-3,000,000 ₮
Хаяг: БЗД




RESIDENCE 60
Хэмжээ:
Өрөө: 1-5
Граж: дулаан зогсоол
Үнэ: 1750-2650 \$
Хаяг: БЗД, 4-р хороо



ИХ МОНГОЛ РЕЗИДЕНС
Хэмжээ: 195 айлын
Өрөө: 3-4 /сонголт/
Граж: Газар доорх байгууламж бүхий 165 граж
Хаяг: БЗД



BLUE GEM-4
Хэмжээ: 15 давхар
Өрөө: Сонголттой
Граж: байгаа
Үнэ: 2,800,000-3,200,000 ₮
Хаяг: БГД, UB Place-ын хажууд



ЗАЙСАН ГОЛДЕН ВИЛЛ
Хэмжээ: 100 айлын орон сууц
Өрөө: 3-5 /сонголттой/
Граж: 150 автомашины зогсоол
Үнэ: 3,500,000-3,800,000 ₮
Хаяг: ХУД, 11-р хороо



NARAN PLACE
Хэмжээ: 120 айлын тохилог сууц
Өрөө: 2-5 /сонголттой/
Граж: давхар зогсоол /төлөвлөсөн/
Хаяг: БЗД, 6-р хороо

© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Евробүсийн сэргэлт тогтвортой үргэлжилж байна

Евробүсийн гишүүн 19 улсад өнгөрсөн онд ажилгүйдэл буурч, ХБНГУ-д үйлдвэрлэл өсчээ. > 10

АНУ-д төвлөрдөг үйлдвэрлэгчдэд энэ жил ивээлтэй

Ам.долларын ханш чангарсан нь гадаадад үйл ажиллагаа явуулдаг АНУ-ын компаниудад таагүй нөлөөтэй. > 10

Daimler анх удаа өрсөлдөгчийнхөө урд гарлаа

Хөлбөмбөгийн нэр томъёогоор үнэлэх аваас 2016 онд Daimler компани BMW-г 2:1-ээр хожлоо. > 10

Ардчилсан намынхан Трампын томилгооны эсрэг




ВВМ©

Тиллерсоны компани Роснефть компанитай хамтран Хойд мөсөн далайд хайгуулаа өргөжүүлэхээр шийдвэрлэж, ноён Путин түүнийг Найрамдлын одонгоор шагнажээ.

Төлөөлөгч асан Мэтью Миллер “Түүнд расизмын хандлага болон иргэний эрхийн хэрэгжилтийг эсэргүүцэж байсан талаар нь хатуухан асуулт тавигдах байх” гэжээ.

1986 онд Сешшионз холбооны шүүхэд ажил аваад байхдаа хамт ажилладаг хар арьст шүүгчийг “жаал” гэж дуудсан тухай яриа бий. Гэвч түүнийг одоо Ларри Томпсон, Кен Блэквел зэрэг нэлээд нөлөөтэй хар арьст улстөрчид дэмжиж байгаа. Томилгоог хэлэлцэх хоёр өдрийн чуулган өчигдөр эхэллээ.



Том Прайс

Эрүүл мэндийн сайдад нэр дэвшсэн, Конгрессийн гишүүн Том Прайс мэс засалч мэргэжилтэй агаад АН-ынхан сайтар нягталбал зохих хүний нэг гэж үзжээ. Хамтрагчдынх нь зүгээс онц эсэргүүцэл тулгаргахгүй боловч сенат дахь АН-ын бүлэг ноён Прайс Эрүүл мэндийн хууль дээр ажиллаж байхдаа 300000 ам.долларын хувьцаа арилжсаныг шалгах ёстой асуудал гэдэг. Тэд Конгрессийн ёс зүйн хороонд хандаж, уг арилжаа хууль зөрчсөн, эсэхийг магадлахыг уриалсан байна. Нөгөө талаар энэ хүн Барак Обамагийн санаачилсан Obamacare хөтөлбөрийн хувь заяаг шийдэхэд гол үүрэг гүйцэтгэх тул АН-ын анхаарлыг татаж байж болох юм.

Байгаль хамгаалах агентлагийн тэргүүний суудлыг авч магадгүй Скотт Пруитт бол муж улсын хэмжээний улстөрч юм. Тэрбээр Оклахомагийн ерөнхий шүүгч байхдаа Обамагийн захиргаанаас авсан уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээ, тухайлбал Байгаль хамгаалах агентлагийг удаа дараа шүүмжилж байжээ. АН-ын сенатчид Пруиттээс юуны учир уур амьсгалын өөрчлөлтийг шийдэхэд үл итгэх байр сууринаас ханддагийг тодруулах аж. Түүнчлэн түүнийг газрын тос, байгалийн хийн аж үйлдвэртэй ойрын холбоотой гэж яригддагийг магадлах нь зүйтэй гэж үзжээ.



Скотт Пруитт

Байгаль хамгаалах зөвлөл хэмээх нөлөө бүхий бүлгийн тэргүүн Реа Сух “Дөчин жилд гарсан дэвшилд тэрбумтнууд, хатуу түлшийг дэмжигч, хэт үзэлтнүүд аюул учруулж эхэллээ” гэсэн юм. Гэхдээ Ардчилсан намынхны дайралт БНН-ын гишүүдийг Пруиттийн эсрэг санал өгөхөд хүргэх нь юу л бол. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай шинжлэх ухаанд үл итгэх үзэл тус намынханд гүнзгий суусан агаад тэд нефтийн аж үйлдвэрийг дэмжихэд чадах бүхнээ хийх эрмэлзэлтэй байгаа билээ.



Энэ долоо хоногт эхэлж буй шинэ засаг захиргааны таван гол албан тушаалтны томилгоог батлах хэлэлцүүлэг нэлээд зөрчилтэй болох төлөвтэй байна. Трампын нэрдэвшүүлсэн хүнийг Ардчилсан намынхан эсэргүүцээд зогсохгүй БНН-ын зарим төлөөлөгч шүүмжилж байгаа. Энэ нь Трампын гол томилогчдын нэгийг цуцлахад хүргэх эрсдэл үүсгэв.

Тиллерсоныг нефтийн салбарынхан болон Тагнуулын төв газрын дарга асан Роберт Гейтс, Төрийн нарийн бичгийн дарга асан Кондолиза Райс зэрэг хүмүүс маш өндрөөр үнэлдэг. Гэвч түүний томилгоо Трампын Орост хандах бодлогын улмаас

цуцлагдаж болзошгүй юм. БНН-ын Линдси Грэм, Жон МакКейн зэрэг нэртэй сенатчид NBC телевизийн “Хэвлэлийнхэнтэй уулзалт” нэвтрүүлэгт оролцоходоо Тиллерсоны талаар бүрэн шийдээгүй байгаагаа хэлжээ. МакКейн “Надад Тиллерсоны Путинтэй холбогдох харилцааны талаар нэмж тодруулах зүйл байгаа” хэмээв. Ноён Грэм ялангуяа Оросын асуудлаар Трампын бодлогыг эсэргүүцдэг илэрхийлээд “Би шаардлагатай үед үгүй гэж хэлэх үүрэгтэй” гэсэн байна.

БНН-ын өөр нэг сенатч, гадаад харилцааны хорооны гишүүн Марко Рубио Крым, Украин, Сири болон хакерийн асуудлаар Оросын эсрэг хоригийг чан-

гатгахыг уриалав. Мөн хэрвээ Тиллерсон Путиний талаар зөвлөн байр суурь баримталж, хоригийг цуцлахыг дэмжвэл түүнийг томилохын эсрэг санал өгнө гэжээ. Сенатын цөөнхийн бүлгийн тэргүүн Чак Шумерс ярихдаа Ардчилсан нам найман



Жефф Сешшионз

албан тушаалд нэр дэвшигчийг онцлон авч үзэхээ мэдэгдсэн. Үүнд, Шүүх, Эрүүл мэнд, Байгаль хамгаалах, Боловсрол, Хөдөлмөр, Төсвийн менежмент болон Сангийн яам, агентлагуудын тэргүүн багтсаны дотор Тиллерсоны нэр байгаа юм.

Шүүх яамны сайдад нэр дэвшсэн Жефф Сешшионзын хувьд урьд нь арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл гаргаж байсан гэх боловч түүний томилгоонд хоёр намаас онц саад учрахгүй байх гэж ажиглагчид үзэж байна. Тэрбээр Алабама мужийн шүүгчийн албыг 20 жил хашсан хатуу бодлоготой хүн. Түүнийг сенатын хуулийн хорооны гишүүд өндөр үнэлдэг. Шүүх яамны хэвлэлийн

Киприйг дахин нэгтгэх хэлэлцээ

Артур Бисли

Киприйн удирдагчид Газрын дундад тэнгис дэх тус арлын хуваагдлыг арилгах хэлэлцээг олон жилийн дараа эхэллээ. НҮБ-ын төлөөлөгч уг хэлэлцээг “Олон арван жил үргэлжилсэн угсааны хагарлыг зохицуулахын тулд үнэнтэй нүүр тулах мөч” хэмээн үнэлжээ. Кипр дэх Грекийн бүсийн тэргүүн Никос Анастасиадес болон Туркийн талын удирдагч Мустафа Акинчи нар Швейцарийн Женев хотноо уулзаж буй нь олон удаа амжилтад хүргээгүй нэгдэх оролдлогод түүхэн эргэлт гаргах боломж гэж ажиглагчид үзэж байна.

Пүрэв гарагаас Грек, Турк, Британийн Засгийн газрын төлөөлөгчид уг хэлэлцээнд оролцохоор ирэх аж. Женевийн хэлэлцээг хариуцсан НҮБ-ын төлөөлөгч Норвегийн иргэн Эспен Барт Эйде “Тохируулгад хүрэх нь хүнд үйл явц боловч боломжгүй зүйл биш. Бид эцийн шатандаа орлоо” хэмээн мэдэгдэв. 1974 онд Туркийн цэргүүд Кипрт нэвтэрч, арлын хойд хэсгийг эзлэн авснаас хойш энд угсаатны хагарал эхэлсэн түүхтэй. Грекийн тал арлыг өөртөө нэгтгэхийн тулд Кипрт төрийн эргэлт зохион байгуулах оролдлого хийсэн гэх шалтгаар Анкара цэргээ ийш илгэсэн билээ. НҮБ зөвхөн Анкара хүлээн зөвшөөрсөн арлын

хэсэг болон Европын холбооны гишүүн Грекийн бүсийг заагласан тусгаарлах зурвас байгуулж, энхийг сахиулах үйл ажиллагаа хэрэгжүүлсээр ирсэн.

НҮБ-ын ивээл доор болсон хуваагдлыг арилгах асуудлаар өмнөх хэлэлцээнүүд 2004 онд амжилтгүй төгссөн юм. Уг гэрээгээр бүх нийтийн санал асуулга явуулахад Киприйн туркууд дэмжсэн боловч, грекууд эсэргүүцсэн билээ. Ноён Анастасиадес, Акинчи нар Кипр арал дээр хоёр мужаас бүрдсэн улс байгуулж, угсаатны хоёр бүлгийн дунд эрх мэдлийг хуваарилан холбооны зарчим дээр улсын үйл хэргийг явуулахыг зорьж байгаа юм. Хоёр удирдагч лхагва гарагт уулзахадаа хоёр талаас газар нутаг солилцох газрын зураг дээр ярилцахаар төлөвлөжээ. Аюулаас хамгаалах хамгийн явигтай асуудлыг тохиролцох үлдээд буй агаад угтаатны хоёр бүлгээс ээлжлэн Ерөнхийлөгч сонгогдох ба улсын төсөв санхүүг удирдах асуудлыг нэгэнт зөвшилцсөн аж.

Ноён Барт Эйде хэлэхдээ хоёр удирдагчийн хооронд 19 сар үргэлжилсэн хэлэлцээнд мэдэгдэхүйц ахиц гарсныг онцлов. Ямар ч тохиролцоонд хүрлээ шууд оролцогч Грек, Турк улсуудаас гадна Британийн дэмжлэгийг авах ёстой. Учир нь 1960 онд Нэгдсэн вант улс

НҮБ-ын зааглах бүсэд байрладаг “эзэнгүй хот” хэмээн нэрлэгдэх болсон Вароша сууринг сэргээн босгож, нийтийн үйлчилгээ, цагдаа хүчнийг байрлуулахад 2-3 тэрбум евро хэрэгтэй.

Кипрээс цэргээ гаргахдаа энэ гурван улс аралд цэрэглэн оролцох эрхтэй гэсэн гэрээ байгуулсан билээ.

Брюссель дэх Европын бодлогын хүрээлэнгийн ахлах шинжээч Аманда Пол Киприйн нэгдсэн улсыг байгуулах засаг захиргаа, дэд бүтэц, арлын хэсгүүд салан тусгаарлахад нүүн шилжсэн хүмүүст олгох

нөхвөр зэрэгт 10 тэрбум орчим евро шаардлагатайг мэдээлжээ. Тэрбээр олон улсын болон орон нутгийн мэргэжилтнүүдтэй зөвлөлдсөний эцэст НҮБ-ын зааглах бүсэд байрладаг “эзэнгүй хот” хэмээн нэрлэгдэх болсон Вароша сууринг сэргээн босгох. Нийтийн үйлчилгээ, цагдаа хүчнийг байрлуулахад 2-3 тэрбум евро хэрэгтэй гэж

тооцоолсон байна.

Түүний хэлснээр “Албан ёсоор зардлыг тооцсон зүйл байхгүй боловч хөрөнгийн асуудлыг цаашид хүлээлгэж болохгүй тул эхлээд 10 тэрбум хүртэл евро гаргах шаардлагатай” аж. Түүнчлэн арлын Туркийн хэсгээс Анкарад төлөх өрийн асуудал шийдэгдээгүй байна. Уг өрийн хэмжээг дипломатууд

40 жилийн эзэллэг, баталгааны эцэст 4-10 тэрбум орчим еврод хүрсэн байх ёстой гэж үзэж байна. Түүнчлэн аюулгүй байдлын хамгийн ноцтой асуудлын нэг бол аралд байрладаг Туркийн 35000 цэргийн алба хаагчийг хэрхэн гаргах ажлыг тохиролцох явдал юм.



Syndicated articles from
FINANCIAL TIMES

© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Клейр Жонс

Бүс нутгийн хэмжээнд ажилгүйдэл буурч, ХБНГУ-д үйлдвэрлэлийн хэмжээ ихсэж буй нь евробүсийн эдийн засаг цаашид тогтвортой хөгжихийн баталгаа болов. Евробүсийн гишүүн 19 улсад өнгөрсөн арваннэгдүгээр сард ажилгүйдлийн хэмжээ 2009 оны долдугаар сараас хойш үнэмлэхүй буурч 9.8 хувь хүртэл багасав. Тус бүсийн гол эдийн засаг ХБНГУ-д аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ тус сард 0.4 хувиар өссөн нь аравдугаар сард гаргасан урьдчилсан тооцооноос давлаа.

Статистикийн энэхүү эерэг үзүүлэлт нь өнгөрсөн онд Европ тивийг дайрсан цуврал цохилт эдийн засгийн сэргэлтэд саад болж чадаагүйг харуулж байна. Их Британи Европын холбооноос гарахаар шийдвэрлэж, АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Дональд Трамп ялалт байгуулж, Үндсэн хуулийн шинэчлэлийн талаар ард түмний дэмжлэг авч чадаагүй Италийн Ерөнхий сайд Маттео Ренци огцорсон нь нийт Европыг цочоосон.

Статистикийн шинэхэн өгөг-



BMM©

Евробүсийн сэргэлт тогтвортой үргэлжилж байна

дөл нь Европ тивд бизнесийн нөхцөл энэ онд сайн дүнтэй гарахын дохио болж байна. Бизнесийн идэвхийн гол хэмжүүр, худалдан авах менежерийн индекс (PMI) өнгөрсөн оны

арванхоёрдугаар сард 2011 оны тавдугаар сараас хойш тохиолдож байгаагүй өсөлттэй гарлаа. Тус тивийн эдийн засгийн өсөлт сүүлийн зургаан жилд тохиолдож байгаагүй

эртэй өсөж байна.

Сүүлийн шинэхэн судалгаа, статистик тоо баримт нь евробүсийн эдийн засгийн эмзэг сэргэлт удаан үргэлжлэхгүй гэсэн түгшүүрийг ч намжаав.

“Евробүсийн эдийн засагт хэд хэдэн хүчин зүйл таатай нөлөө үзүүлж байгаа. Үүнд, түүхэн доод хэмжээндээ хүрсэн бодлогын хүү, санхүүжилтийг хүртээмжтэй болгож буй мөн-

гөний нийлүүлэлтийг ихэсгэх бодлогыг дурдаж болно. Ам.доллартай харьцах еврогийн ханш буурсан нь экспорт өсгөлөө” хэмээн PMI-ийн өгөгдөл бүрдүүлсэн IHS Markit-ийн

эдийн засагч Крис Уильямсон тайлбарлав.

Гэхдээ Трампын засаглал, Brexit-ийн үр дагавар зэрэг сэтгэл зовоох зүйлс хэвээр байгааг эдийн засагчид, албаны хүмүүс анхааруулж байна. Протекционизм нь АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн кампанийн үндсэн сэдэв байж ирлээ. Brexit нь цаашид евробүсийн гадаад худалдааны гол түншүүдэд нөлөөлж таарна. Евробүсийн гурав дахь гол эдийн засаг Италид банкны хямрал нүүлж болзошгүй.

“Трамп буруу юм хийгээд байвал зах зээл ухраад л байх болно” хэмээн AXA IM Research and Investment Strategy-ийн судалгаа харуулсан захирагч Лоренс Бүүн тайлбарлав. “Ер нь бизнесийн үйл ажиллагаанд өсөлт, бууралттай давтамж заавал байдаг. Тэгэхээр сэргэлт эхлээд хоёр дахь жилдээ л явж буй хэрэг. Иймд эдийн засаг цаашид ч сэргэнэ гэж ойлгох хэрэгтэй” хэмээн ноён Бүүн өгүүлж байна.

Европын комиссын статистик судалгаа харуулсан хороо болох Eurostat-аас гаргасан ажлын байрны үзүүлэлтийг үзвэл өнгөрсөн онд ажилгүйдэл нийт Европын хэмжээнд буурчээ. Энэхүү эерэг үзүүлэлт ялангуяа Португал зэрэг евробүсийн эдийн засгийн хүндрэлтэй бүсэд онцгой сайн гарлаа. Тус улсад 2015 оны арваннэгдүгээр сард ажилгүйдлийн түвшин 12.3 хувьтай байсан бол жилийн дараа 10.5-д хүртлээ багасчээ. Харин Италид ажилгүйдлийн хэмжээ өссөн. Мөн нийт евробүс даяар 16-25 насны залуусын дундах ажилгүйдлийн хэмжээ сэтгэл түгшим буюу 21.2 хувьтай байгаа юм.

FT

АНУ-д төвлөрдөг үйлдвэрлэгчдэд энэ жил ивээлтэй

Жессика Дай, Мамта Бадкар

Ундаа үйлдвэрлэгч компаниудын хувьд илүү том байх нь тэр бүр сайн байдаггүй бололтой. Goldman Sachs-ийн шинжээчид даваа гарагт Coca-Cola-ийн хувьцааны зэрэглэлийг “Sell” болгон бууруулж, Dr Pepper Snapple-ийнхийг “Neutral” болгон өсгөлөө. Энэ оны улс төрийн ерөнхий чиг хандлага нь дэлхий даяар үйл ажиллагаа явуулдаг үндэстэн дамнанас компаниудад бус, АНУ-д үйл ажиллагаагаа төвлөрүүлдэг үйлдвэрлэгчдэд илүү ээлтэй байх төлөвтэй.

Сүүлийн 14 жилд ханш нь үнэмлэхүй чангараад байгаа ам.доллар 2017 онд Coca-Cola зэрэг үндэстэн дамнанас компаниудын бизнест таагүй нөлөө үзүүлэх нь гарцаагүй. Борлуулалтын үлэмж хэсэг нь гаднын зах зээлээс хамаардаг АНУ-ын компаниудын хувьд ногоон дэвсгэртний ханшаас шалтгаалан валют солих ажил бэрхшээлтэй болж хувирна. Ийм компаниудын орлого ялангуяа Латин Америк, БНХАУ зэрэг хөгжиж буй зах зээлээс ихээхэн хамаардаг.

Трампын засаг захиргаа АНУ-аас гадна голчлон ажилладаг

компаниудын татварыг ихэсгэх гэж байгаа нь Coca-Cola зэрэг үндэстэн дамнанас үйлдвэрлэгчдэд хохиролтойг Goldman Sachs нь үндэстэн дамнанас Procter & Gamble компанийн хувьцааны зэрэглэлийг ч “Sell” болгон бууруулжээ. Гэхдээ АНУ-ын үндэстэн дамнанас компаниуд гадаадаас олсон орлогоо дотооддоо татах санаачилгыг Трампын засаг захиргаа дэмжиж чадвал байдал өөрчлөгдөж болзошгүй. Органик бүтээгдэхүүнийх нь борлуулалт харьцангуй удаан байгаа Coca-Cola компани нэгтгэх, худалдан авах аргаар (M&A) бүтцийн шинэчлэл өрнүүлэх нь чухал хэмээн Goldman үзэж байна.

АНУ-ын эрчим хүчний салбар S&P-ийн тооцоогоор хамгийн их буюу 1.3 хувийн уналттай байна. АНУ-ын газрын тосны индекс West Texas Intermediate-ийн үнэ 2.6 хувиар унаж, баррель нь 52.60 ам.доллараар үнэлэгдэх болов. Дэлхийн бенчмарк Brent-ийн үнэ 2.6 хувиар унаж, баррель нь 55.61 ам.долларт хүрч хямдрал. Газрын тосны үнэ буурсан нь АНУ стратегийн газрын тосны нөөцөөсөө найман сая баррелийг зарсантай холбоотой

хэмээн Mizuho Securities-ийн фьючерсийн салбарын захирал Роберт Егер үзэж байна. “Уул нь найман сая баррель гэдэг далайд нулимсантай адил өчүүхэн хэмжээ. Одоогоор зах зээлийн суурь үзүүлэлтэд тоглогчдын сэтгэл зүй нөлөөлөд байгаа юм” хэмээн ноён Егер өгүүллээ.

S&P 500-гийн эрчим хүчний салбарын индекс өнгөрсөн онд бараг 24 хувиар өссөн. Гэхдээ олборлогчдын тохиролцоо хэрэгжих нь эргэлзээтэй дээр АНУ хар алтны үйлдвэрлэлээ өсгөх төлөвтэй байгаа. Үүнтэй холбоотой эрчим хүчний салбарын өсөлт энэ онд 0.7 хувьтай байх төлөвтэй. Даваа гарагийн жин үед АНУ-ын хөрөнгийн биржүүд өнгөрсөн долоо хоногийн үнээ торгох төдий нөхцөлд арилжаа хийж байлаа. Баасан гарагт бараг 20000 давах гэж байсан Dow Jones Industrial Average-ийн индекс 0.2 хувиар буурч, 19920.83 болов. S&P 500 индекс 0.2 хувиар буурч, 2272.60 боллоо. Nasdaq Composite-ийнх 0.2 хувиар өсөж, 5532.73-д хүрэв.

FT



BMM©

Daimler анх удаа өрсөлдөгчийнхөө урд гарлаа

Германы хөлбөмбөгийн лигийн сүүлийн 10 жилийн түүхэнд Штутгартын VfB (VfB Stuttgart) Мюнхений Баварь (FC Bayern München) хожиж байсан удаагүй. Харин компаниудын өрсөлдөөний түүхэнд швабууд баварчуудын өмнө бардамнах шалтгаан гараад ирлээ.

Daimler компани 2016 онд 2080000 ширхэг Mercedes-Benz борлуулснаа ням гарагт зарлав. Энэхүү амжилт нь Мюнхенд байрладаг өрсөлдөгч BMW компанийнхаас илүү байгаа юм. Daimler нь 2020 он гэхэд дэлхийн дээд зэрэглэлийн автомашин үйлдвэрлэгч гол компани гэсэн алдраа эргүүлж авна хэмээн бүр 2011 онд амласан нь ийнхүү биеллээ оллоо.

Борлуулалтаар тогтоосон амжилт нь Daimler-ийн ерөнхий захирал Дитер Цетшегийн бахархлыг төрүүлж байгаа нь дамжиггүй. Тэрбээр инженерүүдийнхээ бус, хэрэглэгчдийнхээ хэрэгцээ сонирхолд анхаарч ажилладаг нь компанийн ажиллагаанд хүндрэл учруулах нь цөөнгүй. Шинэ тайлан Mercedes-ийн борлуулалт сүүлийн зургаан жилийн турш хоёр оронтой тоогоор хэмжигдэж ирсэн амжилтыг бататгаж өглөө.

Daimler нь өрсөлдөгч BMW-ийн нэгэн адил Хятад дахь эрэлт, лизингийн үйлчилгээний ачаар борлуулалтаа үлэмж өсгөсөн. Энэхүү чиг хандлага ойрын ирээдүйд ч хэвээр байх төлөвтэй. Гэхдээ зах зээлд чухал байр эзэлдэг загваруудаа өнгөрсөн онд бүгдийг шинэчилсэн нь дахиад давтахад бэрх ажил юм.

Тус компани компакт буюу жижиг оврын автомашиныхаа шинэчлэлд илүүтэй анхаарсан нь оновчтой арга хэмжээ болжээ. Хуучны хайрцаг маягийн хийцтэй A-классын загварыг долгио хийцтэй болгон шинэчилсэн нь хэрэглэгчдийн таашаалд нийцлээ. Үүний зэрэгцээ SUV ангиллын загварынх нь борлуулалт өнгөрсөн онд эрс өсчээ. Үүний дунд тус компанийн SUV-ийн борлуулалт BMW-ийнхтэй адилаар нийт борлуулалтын гуравны нэгийг эзэлдэг болоод байна.

Өрсөлдөгч хоёр компанид 2017 он ширүүн жил байх болно. BMW-ийн хувьд энэ оноос борлуулж эхлэх шинэ 5-Series, 2018 оноос зах зээлд нийлүүлэх 3-Series загварууд орлогын гол эх сурвалж. Тус компанийн үйлдвэрлэдэг дан чахилгаан хөдөлгүүрт загварууд нэг хэсэгтээ борлуулалт муу, ашиг бага байх төлөвтэй. Цахилгаан

хөдөлгүүрт машины зах зээлд Mercedes-ийн амжилт арай бага ч 2018 онд хэдэн шинэ загвар танилцуулахаар амласан.

Герман бус өрсөлдөгчид ч өнгөрсөн оныг амжилт арвин үдлээ. Jaguar Land Rover 2016 онд 580000 ширхэг автомашин борлуулсан нь 2011 оны үзүүлэлтээс хоёр дахин өндөр үзүүлэлт юм. Явцуу салбарт тоглогч Tesla компани 2016 онд 76000 ширхэг автомашин зарж дөнгөсөн. Гэхдээ тус компанид өгсөн захиалгын хэмжээ өнгөрсөн онд 50 хувиар нэмэгджээ.

Орлогоо сайжруулах гэвэл заавал үйлдвэрлэлийн хэмжээг өсгөх албагүй. Хүү, татвар, элгдэл хоргодол тооцохоос өмнөх орлоготой харьцуулснаар Daimler-ийн лизингийн сүлжээний өрийн үлдэгдэл өрсөлдөгч BMW-ийнхаас арай их. Гэхдээ BMW-ийн хувьцаа ноён Цетше ам гарсан 2010 оноос хойш байнга Daimler-ийнхаас илүү явж ирлээ.

Хөлбөмбөгийн нэр томьёогоор үнэлэх аваас 2016 онд Daimler компани BMW-г 2:1-ээр хожсон хэрэг. Харин энэ онд 1:1 гэсэн харьцаагаар хоёр тал хайнцаж таарна хэмээн мэргэжилтнүүд таамаглаж байна.

FT



BMM©

Эдийн засаг

ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ

Хоёр хувийн өсөлттэй жил

Монголын эдийн засаг энэ онд хоёр хувиар өснө

Г.Илч
ЗГМ

Уналт зогсож, өсөлт ирнэ. 1.6 хувиар уруудсан Монголын эдийн засаг 2017 онд хоёр хувиар тэлэх нь. Ийм өөдрөг төлөвийг Дэлхийн банкнаас өчигдөр танилцуулав. 189 орныг эгнээндээ элсүүлсэн тус банк манай эдийн засгийг агшилтаас ангижирч, тэлэлтээр тэтгэгдэнэ гэж үзэж байна.

Шинэ он айлчлан ирээд удаагүй ч өнгөрсөн оны макро эдийн засгийн үзүүлэлтүүд хүлээгдэж буй. Үндэсний статистикийн хороо энэ улиралд багтааж ДНБ-ий өөрчлөлтийг танилцуулах товтой. Үүнээс урьтаад улиран одсон 2016 оны ДНБ-ийг Дэлхийн банк тооцжээ. Өнгөрсөн оны жилийн эцсийн гүйцэтгэлээр Монголын эдийн засаг 0.1 хувиар тэлсэн гэж таамагласан байна. Цаашлаад өсөлт ирэх онд 3.5, 2019 онд 3.7 хувьд хүрч, эрчээ авах аж.

Дэлхийн банк өсөлт өгүүлсэн “захиа”-ндаа сорилтыг ч давхар дайжээ. Монголчууд энэ онд амаргүй сорилттой цөөнгүй нүүр тулна. Тухайлбал, түүхий эдийн үнийн уналтаас улбаалсан хүндрэл гүнзгийрч мэдэхээр байна. Иймд макро эдийн засгийн мэргэж бодлого, оновчтой тохируулга хийх шаардлагатай. Эрсдэл агуулж буй ийм нөхцөл байдалтай зэрэгцээд манай гол худалдан авагчийн “хэтэвч” ч өмнөх оноос ахихгүй нь.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Б.Тамир: Шинэ бүтээгдэхүүн нийлүүлэхээр зорьж байна

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM

“Хөрөнгө оруулагч үндэстэн” компани Монголын хөрөнгийн биржээр хувьцаагаа тун удахгүй арилжаалах гэж байна. Энэ нь хөрөнгө оруулагчдад ямар боломж нээж өгөх талаар тус компанийн гүйцэтгэх захирал Б.Тамиртай ярилцлаа.

-Танай компани энэ оны эхний улиралд хувьцаагаа гаргахаар төлөвлөж байгаа. Нээлттэй компани болох бэлтгэл хэр хангаж байна?

-Бид “Хөрөнгө оруулагч үндэстэн” хувьцаат компаниа үүсгэн байгуулаад нэг жил болж байна. Хоёр хоногийн өмнө манай компани нэг нас хүрсэн. Хувьцаагаа олон нийтэд гаргахын тулд холбогдох байгууллагуудад хандаж, шаардлагатай бичиг баримтуудыг бүрдүүлж, улмаар хуулийн хүрээнд бэлтгэл ажил хийж гэгдэх шатандаа явж байна. Тухайлбал, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвд хамааралтай ажлууд үндсэндээ цэгцрээд байгаа. Удахгүй Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид албан ёсоор хүсэлтээ хүргүүлнэ.

-Манай улсын эдийн засгийн ноцол амаргүй байна. Ийм үед дээрх алхмыг хийх нь хувьцааны ханшид сөргөөр нөлөөлөх магадлалтай. Үүсч болох эрсдэл болон боломжийг хэрхэн тооцоолж байгаа вэ?

-Хувьцаагаа Цагаан сараас өмнө Монголын хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалахаар төлөвлөж байгаа. Хэдийгээр манай улс эдийн засгийн хямралтай ч хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ асар их байна. Энэхүү хэрэгцээ, шаардлагад нийцэх бүтээгдэхүүний нэг нь манай компанийн хувьцаа байх



С.Батсайхан / ЗГМ

Дэлхийн банк сорилтыг ч давхар дайжээ

БНХАУ-ын эдийн засгийн өсөлт сүүлийн хэдэн жилийн доод цэгт хүрнэ. Энэ онд 6.5 хувиар тэлнэ гэж таамаглажээ. Хятадын эдийн засгийн шинэ хэмнэл зөвхөн Монголд нөлөөлөхгүй. Ази, Номхон далайн гол зүтгүүрийн хурд саарснаас бүс нутаг даяар өсөлт удааширна. Манай бүсийн эдийн засаг ирэх онд 6.2 хувиар тэлнэ. Хятадыг хасаж тооцвол бүс нутгийн өсөлт таван хувьтай

тэнцэнэ. Иймд Ази даяар худалдаа, эдийн засгийн нэгдмэл, нээлттэй бодлогыг баримтлах нь зүйтэй гэж Дэлхийн банкнаас зөвлөж байна.

Өөрөөр хэлбэл, түүхий эдийн үнэ өнгөрсөн онд ёроолын цэгтээ хүрчээ. Одоо өндийх үе нь. Гэхдээ өндөр хэмжээний огцом өсөлт хүлээх хэрэггүй гэдгийг шинжээчид зөвлөж байна. Таваарын ханш алгуур боловч дээшлэхийн хэрээр хөгжиж буй, түүхий эдийн экспортод түшиглэсэн эдийн засагтай улсуудад сэргэлт ирнэ. ОХУ, Бразил зэрэг улсын эдийн засаг өнгөрсөн онд дунджаар

яльгүй буюу 0.3 хувиар л өссөн. Энэ онд эрчээ авч, ойролцоогоор 2.3 хувиар тэлэхээр байгаа аж.

Хөрөнгө оруулалт татарч буй нь зөвхөн Монголд тохиогоогүй. Дэлхий даяар хөрөнгийн урсгал саарч байна. Тодорхойгүй байдал дахь сул хөрөнгө оруулалт. Дэлхийн банк манай гарагийн 2017 оны эдийн засгийг товчхондоо ийн тодорхойлжээ. 2010 онд 10 хувиар өсөж байсан хөрөнгө оруулалт 2015 онд 3.4 хувь болтлоо саарсан. Ялангуяа, хөгжиж буй орнуудыг чиглэх гадаадын хөрөнгө оруулалт үлэмж хэмжээгээр татарч

байгаа. Тиймээс хувийн хэвшилд өргөн боломж олгох нь чухал болохыг Дэлхийн банкны шинжээчид зөвлөж байна.

Манай гарагийн эдийн засаг энэ онд өмнөх оныхоос сэргэнэ. Эдийн засгийн өсөлт 2.7 хувьд хэлбэлзэнэ. Мөнгөний урсгал саарч, хөрөнгө оруулалт хумигдаж байгаа нь дэлхийн эдийн засгийг сул хэвээр үлдэхэд хүргэж байгаа аж. Эдийн засаг дахь боломжийг олж, дэд бүтэц, хүний хөгжлийг чиглэсэн хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэх нь чухал гэж Дэлхийн банкны ерөнхийлөгч Ким Ён Жим өгүүллээ. [ЗГМ]

ЗГМ: ИНФОГРАФИК



[ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ] сонин ХУМ

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА

ДИЗАЙНЕР:

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Мэргэжлийн чиглэлээр их дээд сургууль төгссөн
- Мэргэжлээрээ ажиллаж байсан туршлагатай
- Photoshop, Corel Draw, InDesign, Illustrator болон бусад мэргэжлийн программууд дээр ажиллах чадвартай
- Англи хэлний зохих түвшний мэдлэгтэй

ЕРӨНХИЙ ШААРДЛАГУУД:

- Бүтээлч сэтгэлгээтэй, шинийг санаачлагч
- Харууцлагатай
- Тогтвор суурьшилтай ажиллах хүсэл эрмэлзэлтэй
- Ажлын ачаалал даах чадвартай
- Хувийн зохион байгуулалт, цагийн менежмент сайтай

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛУУД:

- Ажилд орохыг хүсэгчийн анкет
- Ажилд орохыг хүссэн өргөдөл
- Гурван үеийн намтар
- Ерөнхий боловсролын гэрчилгээний хуулбар
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Их, дээд сургуулийн диплом болон мэргэжлийн үнэмлэхний хуулбар
- 2 хувь цээж зураг (сүүлийн 3 сарын хугацаанд авахуулсан байх)
- Оршин суугаа хаягийн тодорхойлолт
- Өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт

Өргөдлийг “Засгийн газрын мэдээ сонин”-ны байранд ирж бөглөх болон baasan.b@zasag.co и-мэйл хаягаар явуулна уу.

Утас: 7010-3131

ЗГМ ТОВЧХОН

» ҮНЭТ ЦААС

245.3

Тэрбум төгрөг. Монголбанк төв банкны 91.3 тэрбум төгрөгийн үнэт цаасыг 14 хувийн хүүтэй арилжлаа. Төв банкны нэг долоо хоногтой үнэт цаасны үлдэгдэл 245.3 тэрбум төгрөгт хүрэв.

» ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

8.6

Тэрбум төгрөг. Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 2016 онд 124 компанийн 17.9 сая ширхэг хувьцааг арилжжээ. Үнийн дүн нь 8.6 тэрбум төгрөгт хүрсэн байна.

» ХӨДӨӨ АЖ АХУЙ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн Их Британи улсаас Монголд суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин Сайд Кэтрин Арнольдыг хүлээн авч уулзлаа. Энэ үеэр Их Британи Улстай органик тэмдгийн зохицуулалтын чиглэлээр хамтран ажиллахаар ярилцав.

» УУЛ УУРХАЙ

7.65

Сая тонн. “Эрдэнэс Таван-толгой” компани өнгөрсөн онд нийт 7.65 сая тонн нүүрс экспортолжээ. Энэ нь 2015 оныхоос 1.8 дахин ахисан дүн.

» ХУДАЛДАА

57

Мянган ам.доллар. Монгол Улс өнгөрсөн оны арваннэгдүгээр сарын байдлаар найман тонн цайг 57 мянган ам.доллараар экспортолжээ.

» ХӨРШ

1.4

Хувь. БНХАУ-ын хэрэглээний үнийн индекс 2016 оны эхнээс хоёр хувьд хүрчээ. 2015 оны мөн үеэс 1.4 хувиар өссөн байна.

» ДЭЛХИЙД

Энэ онд дэлхийн эдийн засаг сэргэнэ гэж HSBC-ийн тайланд дурджээ.

12

Хувь. Казахстаны төв банк бодлогын хүүг таван нэгж хувиар бууруулж, 12 хувьд хүргэв.

11.9

Хувь. Италийн ажилгүйдэл арваннэгдүгээр сард 11.9 хувьд хүрлээ. Энэ нь 2015 оны зургадугаар сараас хойших хамгийн өндөр үзүүлэлт.

» САНХҮҮГИЙН ТОЛЬ

Зах зээлийн үнэ, балансын үнийн харьцаа (Market book-value ratio) Компанийн бүртгэлийн үнэ болон зах зээлийн үнийг харьцуулах замаар компанийг үнэлэхэд ашигладаг харьцаа. Энгийнээр уг харьцаа нь нэгээс их бол уг компанийн хувьцаа дутуу үнэлэгдсэн. Нэгээс бага бол илүү үнэлэгдсэн гэж дүгнэж болно.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ, доллар	2498.75
Евро	2648.18
Япон, иен	21.57
ОХУ, рубль	41.70
БНХАУ, юань	360.77
БНСУ, вон	2.09

